



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/335

Мандалговь

Г Хөрөнгө гаргах тухай Г

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1, Төсвийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар тогтоолын 08 дугаар хавсралт, УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 6 дугаар зүйлийн 6.2, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 06 дугаар 30-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” төслийг хавсралтаар баталсугай.

Хоёр. “Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа” төслийг 3.000.000 /Гурван сая/ төгрөгөөр хөтөлбөр, арга хэмжээний зардлаас санхүүжүүлсүгэй.

Гурав. Дээрх төслийг 2017 оны 08 дугаар сарын 15-ны дотор сонгон шалгаруулахыг Хууль, эрх зүйн хэлтэс /Б.Түвшинбаярт/-т даалгасугай.

Дөрөв. Шалгарсан төслийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж зохих журмын дагуу зохион байгуулахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Хууль, эрх зүйн хэлтэс /Б.Түвшинбаяр/-т, ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



0200687